

**МОНГОЛ УЛС УКРАЙН УЛСЫН ХООРОНД ИРГЭНИЙ БОЛОН
ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ
(1995.6.27)**

Монгол улс Украин улсын “цаашид хэлэлцэн тохирогч талууд гэх” Тусгаар тогтнолыг хүндэтгэх харилцан итгэлцэх үндсэн дээр эрх зүйн харилцааны хүрээнд хамтын ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцааг харилцан үзүүлэхээр шийдвэрлэж энэхүү зорилгоор доорхи зүйлийг хэлэлцэн тохиров.

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
Нийтлэг үндэслэл**

**1 дүгээр зүйл
Эрх зүйн хамгаалалт**

1. Хэлэлцэн тохирогч нэг талын иргэн хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэр дээр хувийн болон эд хөрөнгийн эрхийн талаар хэлэлцэн тохирогч тухайн талын иргэний нэгэн адил эрх зүйн хамгаалалт эдэлнэ.Тэд иргэний болон эрүүгийн хэрэг авч хэлэлцэх шүүх буюу эрх бүхий бусад байгууллагад хандах эрхтэй бөгөөд тэдгээрт хүсэлт гаргах буюу байцаан шийтгэх бусад ажиллагаанд хэлэлцэн тохирогч нөгөө талын иргэний нэгэн адил нөхцөлөөр оролцож болно.
2. 1. Дэх заалт нь хэлэлцэн тохирогч талуудын нутаг дэвсгэр дээр тэдний хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдэд нэгэн адил хамаарна.
3. Энэхүү гэрээнд хэрэглэгдэх иргэний хэрэг гэсэн нэр томъёонд мөн худалдаа аж ахуй, гэр бүлийн болон хөдөлмөрийн хэрэг хамаарна.

**2 дугаар зүйл
Эрх зүйн туслалцаа үзүүлэхэд харилцах журам**

1. Хэлэлцэн тохирогч талуудын шүүх болон эрх бүхий бусад байгууллага нь иргэний болон эрүүгийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ хэрэв энэ гэрээнд өөрөөр тогтоогдоогүй бол өөрийн төв байгууллагаар дамжуулан харилцана.
2. Энэ зүйлийн 1-д дурьдсан төв байгууллага гэдэгт:
Монгол Улсын хувьд : Монгол Улсын хууль зүйн яам;
Монгол Улсын дээд шүүх;
Монгол улсын ерөнхий прокурорын газрыг,
Украин улсын хувьд: Украин улсын Хууль Зүйн Яам ,
Украин улсын Дээд Шүүх ,
Украин улсын Ерөнхий Прокурорын газрыг тус тус хэлнэ.

**3 дугаар зүйл
Эрх зүйн туслалцааны хэмжээ**

Эрх зүйн туслалцаа нь энэхүү гэрээнд заасны дагуу баримт бичиг гардуулах тухай даалгавар биелүүлэх болон, иргэний болон эрүүгийн хэргийн талаар байцаан шийтгэх бусад ажиллагаа явуулах мөн шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэхийг хамаарна.

**4 дүгээр зүйл
Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгаврын хэлбэр**

1. Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгавар нь бичгээр үйлдэгдсэн байх бөгөөд дараахь зүйлийг тусгасан байна.
А / Даалгавар өгсөн байгууллагын нэр;
Б/ Даалгавар хүлээн авах байгууллагын нэр;
В/ Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгаварт заасан хэргийн нэр;
Г / Зохигчид яллагадагч, шүүгчдэгч, буюу ялтан хохирогчийн овог нэр, тэдний иргэний харъяалал, эрхэлдэг ажил, байнга оршин суугаа буюу оршиж байгаа газар, хуулийн хувьд нэр, оршин байгаа газар;

Д/ Төлөөлөх хүмүүсийн овог нэр;

Е/ Даалгаврын агуулга мөн түүнийг биелүүлэхэд шаардагдах бусад мэдээ баримт, эрүүгийн хэргийн хувьд үйлдэгдсэн гэмт хэргийн бодит байдлын тухай тодорхойлолт, түүний эрүүгийн хуулийн зүйл анги;

2. Даалгавар болон баримт бичигт эрх бүхий этгээд гарын үсэг зурж даалгавар өгсөн байгууллагын сүлдтэй тамгыг дарсан байна.

5 дугаар зүйл **Даалгавар биелүүлэх**

Хэрэв даалгавар хүлээн авсан хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомжийн дагуу шүүх болон бусад эрх бүхий байгууллагын эрх хэмжээнд даалгавар биелүүлэх үүрэг байхгүй бол энэ тухай шалтгаанаа тайлбарлаж даалгаврыг буцаана.

Хэрэв даалгавар хүлээн авсан байгууллага даалгаврыг биелүүлэх эрх бүхий бус байвал түүнийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх өгч энэ тухай даалгавар өгсө хэлэлцэн тохирогч талд мэдэгдэнэ.

1. Хэрэв даалгавар хүлээн авсан байгууллага даалгаварт заасан хаяг тодорхой бусаас уг даалгаврыг биелүүлэх боломжгүй бол тэрээр зөв хаяг тогтоох талаар зохих арга хэмжээг авч эсвэл даалгавар өгсөн байгууллагаас нэмэлт мэдээ өгөхийг хүснэ.
2. Хэрэв өөр шалтгаанаар нэг сарын дотор “ хугацаа сунгаагүй бол” хаягийг тодруулах буюу даалгаврыг биелүүлэх боломжгүй байвал даалгавар хүлээн авсан байгууллага энэ тухайгаа даалгавар өгсөн байгууллагад мэдэгдэж түүнийг биелүүлэхэд саад болж байгаа шалтгааныг тайлбарлаж ирүүлсэн бүх баримт бичиг буюу маатриалыг буцаах үүрэгтэй. Энэ тохиолдолд даалгавар хүлээн авсан хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллага хэргийг зогсоож болно.

6 дугаар зүйл **Даалгавар биелүүлсэн үр дүнгийн тухай мэдэгдэх**

1. Энэхүү гэрээний 2 дугаар зүйлд зааснаар даалгавар хүлээн авсан байгууллага даалгавар биелүүлсэн үр дүнийг талаар даалгавар өгсөн тухайн байгууллагад бичгээр мэдэгдэх үүрэгтэй бөгөөд даалгавар биелүүлсэн тухай баталгаат баримт бичгийг илгээнэ.
2. Даалгавар биелүүлсэн тухай баталагаат баримт бичигт хүлээж авсан он сар өдөр хүлээн авагчийн гарын үсэг , даалгаврыг биелүүлсэн хүлээн авагч байгууллагын тэмдэг болон даалгавар биелүүлсэн хүний гарын үсэг байх шаардлагатай. Хэрэв хүлээн авагч хүлээн авахаас татгалзаж байгаа бол татгалзаж байгаа тухайн шалтгааныг заасан байх болно.

7 дугаар зүйл **Харилцах хэл**

1. Хэлэлцэн тохирогч талуудын төв байгууллагууд нь бичгээр харицлахдаа өөрийн улсын төрийн хэлийг хэрэглэх бөгөөд хэлэлцэн тохирогч нөгөө талын хэлээр эсвэл Орос хэлрүү хөрвүүлж орчуулгыг хавсаргана.
2. Эрх зүйн туслалцаа үзүүлэх тухай даалгавар болон хавсралт баримт бичгийг даалгавар өгсөн хэлэлцэн тохирогч талын улсын хэлээр үйлдэх бөгөөд даалгавар хүлээн авсан хэлэлцэн тохирогч талын улсын хэлээр эсвэл Орос хэлрүү хөрвүүлсэн баталгаат орчуулгыг хавсаргана.

8 дугаар зүйл **Дипломат төлөөлөгчийн буюу консулын газраар дамжуулан баримт бичиг гардуулах ба байцаан шийтгэх зарим ажиллагааг явуулах**

Хэлэлцэн тохирогч аль нэг талын эрх бүхий байгууллагуудын даалгавраар хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэр дээр томилогдсон дипломат төлөөлөгчийн буюу консулын газар нь өөрийн иргэдэд шүүхийн буюу шүүхийн бус баримт бичиг гардуулж тэдэнд асуулт тавьж болно. Харин эдгээр үйлдэл нь албадлагын шинж чанартай арга хэмжээ агуулах буюу оршин байгаа орны хууль тогтоомжид харшилж болохгүй.

9 дүгээр зүйл **Гэрч хохирогч шинжээчийн талаарх баталгаа**

1. Даалгавар өгсөн хэлэлцэн тохирогч талын шүүх болон эрх бүхий бусад байгууллагын дуудлагаар хүрэлцэн ирсэн даалгавар хүлээн авсан хэлэлцэн тохирогч талын шилжүүлэн өгсөн гэрч хохирогч буюу шинжээчийг алт улсын харъяат болохыг үл харгалзан даалгавар өгсөн хэлэлцэн тохирогч талын улсын хэлийг нэвтрэн орохыг өмнө үйлдсэн эрх зүйн зөрчил болон тэдний гаргасан гэрчийн мэдүүлэг буюу

- шинжээчийн дүгнэлт эсвэл шалгаж байгаа тухайн хэрэгт нь холбогдуулан эрүүгийн хариуцлага татах буюу эрх чөлөөг нь ямар нэгэн хэлбэрээр хязгаарлаж болохгүй.
2. Гэрч хохирогч буюу шинжээч нь цаашид байх шаардлагагүй гэж мэдэгдсэнээс хойш даалгавар өгсөн хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрээс 15 өдрийн дотор гарч яваагүй ба өөрөөс нь үл шалгаалах нөхцөл байдлын улмаас гарч чадаагүй саатсанаас бусад тохиолдолд энэ зүйлийн 1-д заасан баталгааг алдана.
 3. Энэ зүйлийн 1-д дурьдсан дуудлагыг энэхүү гэрээний 2 дугаар зүйлд заасан журмын дагуу гардуулна. Дуудлагын дагуу хүрэлцэн ирээгүй тохиолдолд албадлагын арга хэмжээ хэрэглэх заналхийлэл хийж болохгүй.

10 дугаар зүйл

Эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон зардал

1. Хэлэлцэн тохирогч тал бүр нь өөрийн нутаг дэвсгэр дээр гарсан эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон зардлыг хариуцна.
2. Даалгавар өгсөн хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт дуудагдсан ирсэн гэрч хохирогч шинжээчийн байр, хоол болон замын зардлыг нь даалгавар өгсөн хэлэлцэн тохирогч тал хариуцна. Шинжээч үүнээс гадна шинжилгээ хийсэн шагналыг авах эрхтэй дурьдсан этгээдүүд ямар зардал авах эрхтэйг зарлан дуудах хуудаст заасан байх ёстой.
3. Даалгавар хүлээн авсан хуулийн байгууллага гарсан зардлын дүнг даалгавар өгсөн байгууллагад мэдэгдэнэ. Хэрэв даалгавар өгсөн байгууллага уг зардлыг төлөх үүрэг бүхий этгээдээс нөхөн гаргуулж авсан бол зардал нь даалгавар биелүүлсэн хуулийн байгууллагын орлогод орно.

11 дүгээр зүйл

Эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзах

Хэрэв даалгавар хүлээн авсан хэлэлцэн тохирогч Тал эрх зүйн туслалцаа үзүүлэх нь түүний тусгаар тогтнол, аюулгүй байдал, нийгмийн хэв журам буюу хууль тогтоомжийн үндсэн зарчимд харшилж байна гэж үзвэл эрх зүйн туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно, харин татгалзсан шалтгаанаа даалгавар өгсөн Хэлэлцэн тохирогч Талд мэдэгдэнэ.

12 дугаар зүйл

Эрх зүйн туслалцаа үзүүлэхэд хэрэглэх хууль тогтоомж

1. Даалгавар хүлээн авсан байгууллага эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ өөрийн улсын мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийг хэрэглэнэ.
2. Даалгавар хүлээн авсан байгууллага иргэний хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэхдээ өөрийн улсын хууль тогтоомжийн үндсэн зарчимд харшлахгүй бол Хэлэлцэн тохирогч нөгөө талын байцаан шийтгэх ажиллагааны хэм хэмжээг даалгавар өгсөн байгууллагын хүсэлтээр хэрэглэж болно.

13 дугаар зүйл

Хууль зүйн мэдээлэл солилцох

Хэлэлцэн тохирогч Талууд хүсэлтийн дагуу өөрийн оронд дагаж мөрдөж байгаа эсвэл дагаж мөрдөж байсан хууль тогтоомж болон шүүхийн практикийн талаар бие биедээ харилцан мэдээлэл өгч байна.

Хоёрдугаар бүлэг

Иргэний хэргийн талаархи эрх зүйн туслалцаа

14 дүгээр зүйл

Эрх зүйн туслалцааны хэмжээ

Хэлэлцэн тохирогч Талууд хүсэлтийн дагуу шүүхийн болон шүүхийн бус баримт бичгийг гардуулах хэрэгт холбогдох оролцогчид, гэрч буюу шинжээчийг байцаах, шинжилгээ хийх болон газар дээр нь үзлэг явуулах, баримт нотолгоо цуглуулахтай холбогдсон байцаан шийтгэх бусад ажиллагааг харилцан биелүүлнэ.

15 дугаар зүйл

Шүүхийн зардал болон хураамжийг төлөх

1. Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын хутаг дэвсгэр дээр шүүхийн зардал болон хураамжийг Хэлэлцэн тохирогч энэ талын иргэний нэгэн адил нөхцөл, хэмжээгээр төлнө.
2. Энэ зүйлийн 1 дэх заалтыг Хэлэлцэн тохирогч аль нэг Талын нутаг дэвсгэр дээр тэдний хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдэд нэгэн адил хэрэглэнэ.

16 дугаар зүйл
Шүүхийн зардал, хураамжаас чөлөөлөх

1. Хэлэлцэн тохирогч нэг талын иргэн Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэр дээр энэ талын иргэдийн нэгэн адил нөхцөл, хэмжээгээр шүүхийн зардал, хураамжаас чөлөөлөгдөнө.
2. Шүүхийн зардлаас чөлөөлөх тухай хүсэлт гаргаж байгаа Хэлэлцэн тохирогч нэг талын иргэн оршин сууж байгаа буюу оршин байгаа газраас олгосон түүний эд хөрөнгийн байдал болон өөрийг нь тодорхойлсон баримт бичиг гаргаж өгөх бөгөөд хэрэв хүсэлт гаргагч Хэлэлцэн тохирогч талуудын нутаг дэвсгэр дээр оршин суудаггүй буюу оршин байдаггүй бол өөрийн улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газраас дээр дурьдсан баримт бичгийг авч өгнө.
3. Шүүхийн зардлаас чөлөөлөх тухай хүсэлтийн талаар шийдвэр гаргах шүүх нь дурьдсан баримт бичгийг гаргаж өгсөн байгууллагаас нэмэлт тайлбар гаргуулахаар шаардаж болно.

Гуравдугаар бүлэг
Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх

17 дугаар зүйл
Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх

1. Энэхүү гэрээний хүчин төгөлдөр болсны дараа Хэлэлцэн тохирогч Талууд энэ Гэрээний заалтын дагуу хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэр дээр гаргасан шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба хэрэв шийдвэрийн шинж чанараас шаардлагатай гэж үзвэл түүнийг өөрийн орны нутаг дэвсгэр дээр биелүүлэх үүрэг хүлээнэ.
2. Энэхүү гэрээнд хэрэглэгдэж байгаа шүүхийн шийдвэр гэсэн нэр томъёонд:
Монгол Улсын хувьд- шүүхээс гаргасан шүүхийн шийдвэр, магадлал шүүхийн(шүүгчийн)тогтоол, иргэний хэргийн талаар эвлэрэх тухай хэлэлцээ болон таслан шийдвэрлэх тогтоолын хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбогдсон хэсэг,
Украин улсын хувьд – таслан шийдвэрлэх тогтоолын хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбогдсон хэсэг, шүүхийн (шүүгчийн) шийдвэр, магадлал, тогтоол, иргэний хэргийн талаар шүүхээс батлан гаргасан эвийн хэлэлцээ.

18 дугаар зүйл
Шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай хүсэлт

1. Шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай хүсэлтийг өргөдөл гаргагч шийдвэр гаргасан шүүхэд гаргана. Тэрхүү байгууллага нь энэхүү гэрээний 2 дугаар зүйлд заасан журмын дагуу хэлэлцэн тохирогч нөгөө талын шүүхэд хүргүүлнэ. Хэрэв өргөдөл гаргагч шийдвэрийг биелүүлэх ёстой хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэр дээр оршин суудаг буюу оршин байгаа бол өргөдлийг хэлэлцэн тохирогч энэ талын шүүхэд шууд гаргаж болно.
2. Хүсэлтийг даалгавар хүлээн авсан хэлэлцэн тохирогч талд тогтсон хэлбэрээр үйлдсэн байна. Түүнд дор дурьдсан зүйлийг хавсаргана:
 - 1/ шүүхээс баталгаажуулсан шүүхийн шийдвэрийн хуулбар, хэрэв хуулбарт шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болж биелүүлэх эсэх нь тодорхой заагдаагүй бол энэ тухай шүүхийн магадлалын нэг хувийг хавсаргана;
 - 2/ даалгавар өгсөн хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэр дээр шийдвэрийг биелүүлэх, эс биелүүлэх тухай шүүхийн магадлал;
 - 3/ байцаан шийтгэх ажиллагаанд оролцоогүй зохигчдод зохих журмаар тогтоосон журмын дагуу шүүхийн зарлан дуудах хуудсыг, хэрэв үүрэг хүлээх чадваргүй байсан тохиолдолд түүний хууль ёсны төлөөлөгчид гардуулсныг гэрчилсэн тухай баримт бичиг;
 - 4/ энэ зүйлд дурдагдсан өргөдөл болон холбогдох бусад баримт бичгийн баталгаат орчуулга.

19 дүгээр зүйл
Шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх журам

1. Шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхдээ хүсэлтийг хүлээн авсан хэлэлцэн тохирогч тал өөрийн улсын хууль тогтоомжоор тогтоосон журмын дагуу хэрэгжүүлнэ.
2. Хүсэлт хүлээн авсан эрх бүхий байгууллага уг, шийдвэр нь энэхүү гэрээний шаардлагад нийцэж байгаа эсэхийг авч үзэх бөгөөд хэргийг бүхэлд нь авч шалгахгүй.

20 дугаар зүйл
Хүлээн зөвшөөрөх, биелүүлэх хуулийн хүчин чадал

Хэлэлцэн тохирогч нэг талын шүүх хэлэлцэн тохирогч нөгөө талын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх нь энэ хэлэлцэн тохирогч талын өөрийн шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхтэй адил хүчин чадалтай байна.

21 дүгээр зүйл **Шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхээс татгалзах**

Шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхээс дор дурьдсан тохиолдолд татгалзаж болно:

- 1/ шийдвэрийг гаргасан хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомжийн дагуу уг шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болоогүй буюу биелүүлэх шаардлагагүй бол;
- 2/ шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай хүсэлтийг хүлээн авсан хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомжийн дагуу уг хэрэг нь даалгавар хүлээн авсан хэлэлцэн тохирогч талын шүүхийн онцгой эрх хэмжээгнд харьяалагдах бол;
- 3/ байцаан шийтгэх ажиллагаанд оролцоогүй зохигчдод шийдвэр гаргасан хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомжийн дагуу шийдвэр гаргасан байгууллага шүүхийн зарлан дуудах гардуулаагүй, эсвэл үүрэг хүлээх чадваргүй байсан тохиолдолд түүний хууль ёсны төлөөлөгчийг оролцуулаагүй бол;
- 4/ даалгавар хүлээн авсан хэлэлцэн тохирогч талын шүүхээр нэг зохигчдын хооронд үүссэн тухайн эрх зүйн маргааны талаар хүчин төгөлдөр шийдвэр гаргасан, эсвэл уг асуудал тухайн газарт хэлэлцэгдэж байгаа эсвэл уг хэргийн талаар гурав дахь улсад гаргасан хүчин төгөлдөр шийдвэрийг хүлээн зөвшөөрсөн бол;
- 5/ Хэрэв шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх нь хүсэлт хүлээн авсан хэлэлцэн тохирогч талын тусгаар тогтнол, аюулгүй байдал болон нийгмийн хэв журамд хохирол учруулж болзошгүй бол.

Дөрөвдүгээр бүлэг **Эрүүгийн хэргийн талаархи эрх зүйн туслалцаа**

22 дугаар зүйл **Эрх зүйн туслалцааны хэмжээ**

1. Хэлэлцэн тохирогч талууд даалгавар биелүүлэх хүсэлтийн дагуу эрүүгийн хэргийн талаар гэрч, хохирогч, шинжээч, яллагдагчийг байцаах, нэгжлэг, шинжилгээ, үзлэг хийх болон нотлох баримт цуцлуулахтай холбогдсон байцаан шийтгэх бусад ажиллагаа явуулах, эд мөрийн нотлох баримт ба гэмт хэрэг үйлдсэний үр дүнд авсан баримт бичиг, гардуулах, эрүүгийн хэргийн талаархи ажиллагааны үр дүнгийн талаар харилцан мэдээлж байх үүрэг хүлээнэ.
2. Хэлэлцэн тохирогч нэг тал хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдэж байгаа өөрийн улсын иргэний эсрэг хэлэлцэн тохирогч нөгөө талын хүсэлтээр өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу эрүүгийн хэрэг үүсгэх үүрэг хүлээнэ.

23 дугаар зүйл **Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах үүрэг**

1. Хэлэлцэн тохирогч тал бүр хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдэж байгаа өөрийн улсын иргэний эсрэг хэлэлцэн тохирогч нөгөө талын хүсэлтээр өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу эрүүгийн хэрэг үүсгэнэ.
2. Урьдчилсан мөрдөн байцаалтын материал болон хэлэлцэн тохирогч нэг талын хууль тогтоомжийн дагуу түүний эрх бүхий байгууллагад зохих хугацаанд өгсөн эрүүгийн хэрэг үүсгэх тухай өргөдөл нь хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт мөн адил хүчинтэй байна.
3. Гэмт хэргийн улмаас эд хөрөнгийн хохирол хүлээснээс эрүүгийн хэрэг үүсгэх тухай хүсэлт тавьсан этгээд хэрэв хохирлыг нөхөн төлүүлэх тухай шаардлага тавьсан бол хэрэгт оролцож болно.

24 дүгээр зүйл **Эрүүгийн хэрэг үүсгэх тухай хүсэлт**

1. Эрүүгийн хэрэг үүсгэх тухай хүсэлт нь бичгээр үйлдэгдсэн байх бөгөөд дараахь зүйлийг агуулсан байна:
 - 1/ Даалгавар өгсөн байгууллагын нэр;
 - 2/ Эрүүгийн хэрэг үүсгэх тухай хүсэлт гаргаж явуулсантай холбогдсон үйл явдлын талаархи тодорхойлолт;
 - 3/ Үйл явдал болсон газар ба цаг хугацааны талаар аль болох тодорхой заах;
 - 4/ Үйл явдал нь гэмт хэрэг гэж үзэх даалгавар өгсөн хэлэлцэн тохирогч талын хуулийн баталгаатай эх бичвэр;

5/ Сэжиглэгдэж байгаа этгээдийн овог, нэр, түүний оршин суугаа буюу мэдээлэл болон болоцоотой бол уг этгээдийн гадна төрх, түүний гэрэл зураг ба хурууны хээ;

6/ Хохирогчийн өргөдлөөр үүсгэх эрүүгийн хэргийн хувьд хохирогчийн өргөдөл ба хэрэв эд хөрөнгийн хохирол байвал түүнийг нөхөн төлүүлэх тухай өргөдөл;

7/ Учруулсан эд хөрөнгийн хохирлын хэмжээний талаархи мэдээлэл.

Хүсэлтэд даалгавар өгсөн хэлэлцэн тохирогч талын мэдэлд байгаа урьдчилсан мөрдөн байцаалтын материал болон нотлох баримтуудыг хавсаргана. Гэмт хэргийн зэвсэг болсон ба тийм гэмт хэрэг үйлдсэний улмаас гэмт этгээдийн гарт орсон эд зүйлийг шилжүүлэхдээ 42 дугаар зүйлийн 3 дахь заалтыг харгалзан үзэх хэрэгтэй.

- 23 дугаар зүйлийн 1 дэх заалтын дагуу эрүүгийн хэрэг үүсгэх тухай хүсэлт явуулах үед этгээд нь хэрэг үүсгэх тухай хүсэлт явуулсан хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэр дээр хоригдож байгаа этгээдийг хуяглан хүргүүлэх тухай зөвшөөрлийг зохих албан тушаалтанд гаргана. Шилжүүлэн өгөх ийм этгээдийг энэхүү гэрээний 35 дугаар зүйлийн 1-д заасны дагуу шилжүүлнэ.

25 дугаар зүйл

Баримт бичиг гардуулах, байцаан шийтгэх зарим ажиллагааг биелүүлэх

1. Баримт бичиг гардуулах журам болон эрүүгийн хэргийн талаар байцаан шийтгэх зарим ажиллагаа биелүүлэхийг энэхүү гэрээний 4-6 дугаар зүйлд заасны дагуу хэрэгжүүлнэ.
2. Дээр дурьдсан даалгаврыг явуулахад дараахь зүйлийг заасан байна:
 - Гэмт хэрэг гарсан нөхцөл байдал, гэмт хэргийн зүйл анги болон холбогдох хууль тогтоомжийн заалт.

26 дугаар зүйл

Шилжүүлэн өгөх үүрэг

1. Хэлэлцэн тохирогч талууд энэ гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу өөрийн нутаг дэвсгэрт байгаа этгээдийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахын тулд буюу таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхийн тулд бие биенийхээ хүсэлтийн дагуу шилжүүлэн өгөх үүрэг хүлээнэ.
2. Хэлэлцэн тохирогч хоёр талын хууль тогтоомжид зааснаар зөвхөн гэмт хэрэг гэж үзэх хэрэг үйлдсэн бөгөөд тэр хэрэгт нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахаар шилжүүлэн өгч болно.
3. Зургаан сараас дээш хугацаагаар хорих эсвэл өөр хүнд ял шийтгэл оногдуулах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдийг ял шийтгэсэн бөгөөд хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхээр шилжүүлэн өгнө.

27 дугаар зүйл

Шилжүүлэн өгөхөөс татгалзах

1. Шилжүүлэн өгөхөөс дор дурьдсан тохиолдолд татгалзана:
 - а/ Шилжүүлэн өгөхийг хүссэн этгээд нь хүсэлт хүлээн авсан хэлэлцэн тохирогч талын иргэн буюу эсвэл энэ улсад орогнох эрх олгосон этгээд байгаа бол;
 - б/ Хэлэлцэн тохирогч хоёр талын хууль тогтоомжийн дагуу хохирогчийн гомдлоор үүсдэг хэрэгт эрүүгийн хэрэг үүсээгүй бол;
 - в/ Шаардлага хүлээн авах үед шаардлага хүлээн авсан хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомжид зааснаар хөөн хэлэлцэх хугацаа дууссан, өршөөл үзүүлсэн буюу хууль зүйн бусад үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэж, эсвэл таслан шийтгэх тогтоолыг биелүүлж болохгүй болсон;
 - г/ Шилжүүлэн өгөхийг хүлээн авсан хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт тухайн гэмт хэргийн талаар хуулийн хүчин төгөлдөр болсон таслан шийдвэрлэх тогтоол гаргасан буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон.
2. Шаардлага хүлээн авсан хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт үйлдсэн хэрэгтэй нь холбогдуулан шилжүүлэн өгөхийг шаардаж байгаа бол шилжүүлэн өгөхөөс татгалзаж болно.
3. Шилжүүлэн өгөхөөс татгалзсан тохиолдолд татгалзаж байгаа үндэслэлээ шаардлага өгсөн хэлэлцэн тохирогч талд мэдэгдэнэ.

28 дугаар зүйл

Шилжүүлэн өгөхийг хойшлуулах

Шилжүүлэн өгвөл зохих этгээдийн хувьд хүсэлт хүлээн авсан хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт эрүүгийн хэрэг үүсгэсэн буюу уг этгээд өөр хэргийн учир ял эдэлж байгаа бол эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж дуусгах, ялаа эдэлж дуусгах буюу эрүүгийн хариуцлагын ямарваа нэгэн хуулийн үндэслэлээр чөлөөлөгдтөл шилжүүлэн өгөхийг хойшлуулж болно.

29 дүгээр зүйл

Түр шилжүүлэн өгөх

Хэрэв 28 дугаар зүйлд заасны дагуу шилжүүлэн өгөхийг хойшлуулсан нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хөөн хэлэлцэх хугацаа дуусах эсвэл гэмт хэргийн мөрдөн байцаалтыг хүндрүүлэхэд хүрч болзошгүй байвал үндэслэл бүхий хүсэлтийн дагуу түр шилжүүлэн өгч болно. Харин шилжүүлэхэд хүргэсэн байцаан шийтгэх ажиллагаа нь дуусмагц уг этгээдийг нэн даруй буюу шилжүүлэн өгсөн өдрөөс хойш 3 сараас хэтрэхгүй хугацаанд буцаана.

30 дугаар зүйл

Шилжүүлэн өгсөн этгээдийн байцаан шийтгэх хязгаар

1. Шилжүүлэн өгсөн этгээдийг хүсэлт хүлээн авсан хэлэлцэн тохирогч талын зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах буюу шилжүүлэн өгөх үндэслэл болсон гэмт хэргээс өөр хэрэгт холбогдуулан ял шийтгэл ногдуулж болохгүй
2. Уг этгээдийг мөн хүсэлт авсан хэлэлцэн тохирогч талын зөвшөөрөлгүйгээр гуравдахь улсад шилжүүлэн өгч болохгүй.
3. Шилжүүлэн өгсөн этгээд нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа дууссан ба ял эдэлж дууссан эсвэл ямарваа нэгэн хуулийн үндэслэлээр чөлөөлөгдсөний дараа хүсэлт өгсөн хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрээс 15 хоногийн дотор гарч яваагүй эсвэл яваад сайн дураараа эргэж ирсэн бол хүсэлт авсан хэлэлцэн тохирогч талын зөвшөөрөл шаардахгүй. Уг хугацаанд шилжүүлэн өгсөн этгээд өөрөөсөө үл шалтгаалах нөхцөл байдлын улмаас хүсэлт өгсөн хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрээс явж чадаагүй байсан хугацааг оруулан тооцохгүй.

31 дугаар зүйл

Шилжүүлэн өгөх тухай хүсэлт

1. Шилжүүлэн өгөх тухай хүсэлт нь бичгээр үйлдэгдсэн байх бөгөөд дараах зүйлийг тусгасан байна.
 - Хүсэлт өгсөн байгууллагын нэр
 - Үйлдэгдсэн гэмт хэргийн тодорхойлолт ба үйлдэл нь гэмт хэрэг гэж тооцогдох хүсэлт өгсөн хэлэлцэн тохирогч талын хуулийн заалт;
 - Шилжүүлэн өгөхийг хүссэн этгээдийн овог нэр харъяаллын тухай мэдээ;
 - Оршин суугаа буюу оршин байгаа газар, хувийн байдлын талаарх бусад мэдээлэл мөн түүнчлэн бололцоотой бол гу этгээдийн гаднах төрхийн талаарх тодорхойлолт түүний гэрэл зураг ба хурууны хээ;
 - Учруудсан эд хөрөнгийн хохирлын хэмжээний тухай заалт .
2. ЭБША явуулахаар шилжүүлэх өгөх тухай хүсэлтэд цагдан хорих тухай тогтоолын баталгаатай хувийг хавсаргасан байна.
3. Таслан шийдвэрлэх тухай тогтоолыг биелүүлэхээр шилжүүлэн өгөх тухай хүсэлтэд тогтоолын баталгаат хуулбар түүний хуулийн хүчин төгөлдөр болох тухай магадлал болон уг этгээдийн шилжүүлсэн тухай Эрүүгийн хуулийн зүйл ангийг хавсаргасан байна. Хэрэв ялтны ялын хэсэг хугацааг эдэлсэн буюу хохирлын хэсгийг төлсөн бол мөн энэ тухай мэдэгдэнэ.
4. Энэ зүйлд заасан бүх шаардлагатай мэдээллийг шилжүүлэн өгөх тухай хүсэлтэд хавсаргаагүй бол хүсэлт хүлээн авсан хэлэлцэн тохирогч тал нэмэлт мэдээлэл шаардаж болно. Хэлэлцэн тохирогч нөгөө тал уг хүсэлтэд нэг сараас дээшгүй хугацаанд хариу өгөх бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаантай гэж үзвэл уг хугацааг 15 хоногоор сунгаж болно.
5. Хэрэв уг хугацаанд хүсэлт гаргасан хэлэлцэн тохирогч тал нэмэлт мэдээлэл гаргаж өгч чадахгүй бол хүсэлт хүлээн авсан хэлэлцэн тохирогч тал 32 дугаар зүйлийн дагуу шилжүүлэн өгөхөөр цагдан хорьсон этгээдийг суллаж хэргийн ажиллагааг зогсоож болно.

32 дугаар зүйл

Шилжүүлэн өгөхөөр цагдан хорих

1. Шилжүүлэн өгөх тухай шаардлага хүлээн авмагц даалгавар хүлээн авсан хэлэлцэн тохирогч тал шилжүүлэн өгвөл зохих этгээдийг цагдан хорих арга хэмжээг нэн даруй авна.

33 дугаар зүйл

Шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг хүлээн авахын өмнө цагдан хорих

1. Хойшлуулшгүй нөхцөл байдалд хүсэлт хүлээн авсан этгээд хэлэлцэн тохирогч тал хүсэлт өгсөн хэлэлцэн тохирогч нөгөө талаас цагдан хорих тухай тогтоолын хуулбар эсвэл уг этгээдтэй холбогдуулж гаргасан хуулийн хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх тогтоолыг “ таслан шийдвэрлэх тогтоолы хэсгээс” авахын өмнө уг этгээдийн цагдан хорьж болно. Ингэхдээ шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг нэн даруй

- ирүүлэхээр заасан байх болно. Цагдан хорих тухай тогтоолын хуулбар эсвэл уг этгээдтэй холбогдуулж гарсан хуулийн хүчин төгөлдөр таслан шийдвэрлэх тогтоолыг “ таслан шийдвэрлэх тогтоолын хэсгээс “ баримт бичиг дамжуулж чадах бүхий л аргаар дамжуулна.
2. Цагдан хорих тухай хүсэлтийг биелүүлж чадахгүйд хүрвэл уг шалтгаанаа хэлэлцэн тохирогч нөгөө талд нэн даруй мэдэгдэнэ.
 3. Цагдан хорьсон тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш нэг сарын дотор хэлэлцэн тохирогч нөгөө талаас шилжүүлэн авах тухай хүсэлт ирээгүй бол цагдан хорьсон этгээдийг суллана. Энэ хугацааг хүсэлт өгсөн хэлэлцэн тохирогч талын хүсэлтээр 15 хоногоор сунгаж болно.

34 дүгээр зүйл

Хэд хэдэн улсын хүсэлтээр шилжүүлэн өгөх

Нэг эсвэл хэд хэдэн төрлийн ял оногдуулж болох хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэн өгөх тухай хүсэлтийг хэд хэдэн улсаас ирүүлсэн бол аль хүсэлтийг хангах тухай асуудлыг хүсэлт хүлээн авсан хэлэлцэн тохирогч тал шийдвэрлэнэ.

35 дугаар зүйл

Шилжүүлэн өгөх

1. Хүсэлт хүлээн авсан хэлэлцэн тохирогч тал шилжүүлэн өгөхийг зөвшөөрч байгаа бол уг этгээдийг шилжүүлэн өгөх газар цаг хугацааг хүсэлт өгсөн хэлэлцэн тохирогч талд мэдэгдэнэ.
2. Хэрэв шилжүүлэн өгөх этгээдийг хүсэлт өгсөн хэлэлцэн тохирогч тал нь шилжүүлэн өгөхөөр тогтоосон хугацаанаас хойш 15 хоногийн дотор тогтсон газар хүлээн авахгүй бол цагдан хоригдсон этгээдийг суллана.

36 дугаар зүйл

Дахин шилжүүлэн өгөх

Шилжүүлэн өгсөн этгээд Байцаан шийтгэх ажиллагаанаас буюу эсвэл ял эдлэхээс зайлсхийж хүсэлт хүлээн авсан хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт буцаж ирвэл хүсэлт өгсөн хэлэлцэн тохирогч талын шинэ хүсэлтийн дагуу энэ гэрээний 31 дүгээр зүйлд дурьдсан мэдээ материал гаргуулахгүйгээр уг этгээдийг дахин шилжүүлэн өгч болно.

37 дугаар зүйл

Дамжин өнгөрүүлэх

1. Хэлэлцэн тохирогч тал бүр хэлэлцэн тохирогч нөгөө талын хүсэлтээр 3 дах улсаас хэлэлцэн тохирогч нөгөө талд шилжүүлэн өгөх этгээдийг өөрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэх үүрэг хүлээнэ. Хэлэлцэн тохирогч талууд энэ гэрээнд шилжүүлэн өгч болохгүй гэж заасан этгээдийг дамжуулан өнгөрүүлэхийг зөвшөөрөх үүрэггүй.
2. Дамжуулан өнгөрүүлэх тухай хүсэлтийг шилжүүлэн өгөх хүсэлтийн адил журмаар үйлдэж хүргүүлнэ.

38 дугаар зүйл

Шилжүүлэн өгөх болон дамжин өнгөрүүлэх зардал

Шилжүүлэн өгөх зардлыг уг зардал нутаг дэвсгэрт нь гарсан хэлэлцэн тохирогч талууд хариуцна. Дамжин өнгөрүүлэхдээ холбогдсон зардлыг хүсэлт өгсөн хэлэлцэн тохирогч тал хариуцна.

39 дүгээр зүйл

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны дүнгийн талаар мэдээлэх

Шилжүүлэн өгсөн этгээдийн талаар явуулсан Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны дүнг хэлэлцэн тохирогч талууд бие биедээ мэдээллэнэ. Хэрэв шилжүүлэн өгсөн этгээд шийтгүүлсэн бол таслан шийдвэрлэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсны дараа уг тогтоолын хуулбарыг хүргүүлнэ.

40 дүгээр зүйл

Таслан шийдвэрлэх тогтоол болон ял шийтгэгдсэн талаар мэдээлэх

1. Хэлэлцэн тохирогч тал бүр хэлэлцэн тохирогч нөгөө талын иргэний тухайд шүүхийн гаргасан таслан шийдвэрлэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон тухай мэдээг хэлэлцэн тохирогч нөгөө талд жил бүр мэдээллэж байна.

2. Хэлэлцэн тохирогч талуудын шүүхэр урьд нь ял шийтгүүлж байсан этгээд даалгавар өгсөн хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт эрүүгийн хариуцлагад татагдсан бол түүний ял шийтгэгдэж байсан тухай мэдээг хэлэлцэн тохирогч талууд нэг нэгэндээ хүсэлтээр нь өгнө.

41 дүгээр зүйл **Харилцах журам**

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах шилжүүлэх өгөх хэргийн талаар Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, Украин Улсын Ерөнхий Прокурорын газар хоорондоо харилцана.

42 дугаар зүйл **Эд зүйл шилжүүлэх**

1. Шилжүүлэн өгөх хэлэлцэн тохирогч тал гэмт хэргийн зэвсэг болсон гэмт хэргийн ул мөр хадгалсан эсвэл гэмт хэргийн улмаас олдсон эд зүйл эрүүгийн хэрэгт нотлох баримт гэж тооцогдож болох эд зүйлүүдийг хүсэлт өгсөн хэлэлцэн тохирогч талд шилжүүлнэ. Хэрэв уг этгээдийн нас барсантай холбогдуулж эсвэл өөр бусад шалтгаанаар шилжүүлэн өгч болохгүй бол дээрх эд зүйлийг хүсэлтийн дагуу шилжүүлнэ.
2. Хэрэв энэ зүйлийн 1-д заасан эд зүйл нь өөр эрүүгийн хэргийн ажиллагаанд шаардлагатай гэж үзвэл хүсэлт хүлээн авсан хэлэлцэн тохирогч тал уг эд зүйлийг түр саатуулж болно. Хүсэлт гаргасан хэлэлцэн тохирогч талд харилцан тохиролцсоны дагуу түүнийг түр шилжүүлж болно.
3. Хүсэлт өгсөн хэлэлцэн тохирогч талд шилжүүлэн өгсөн эд зүйл нь гуравдагч этгээдэд шилжих эрх хүчинтэй хэвээр байна. Уг хэргийн ажиллагаа дууссаны дараа уг эд зүйлийг шилжүүлэн өгсөн хэлэлцэн тохирогч талд буцаан өгнө.

43 дугаар зүйл **Хуулийн байгууллагын ажилтанд туслалцаа үзүүлэх**

Хэлэлцэн тохирогч талуудын хуулийн байгууллага нутаг дэвсгэрт нь зугтан очиж нуугдсан гэмт хэрэгтэн оршин суугаа газар нь тодорхойгүй байгаа этгээдийг эрэн сурвалжлах баривчлах хүргэх ажлаар оролцсон хэлэлцэн тохирогч нөгөө талын хуулийн байгууллагын ажилтанд бүх талын шаардлагатай туслалцаа үзүүлж тэдний аюулгүй байдлыг хангана. Шүүхэд шилжүүлэхээс өмнөх урьдчилсан мөрдөн байцаалтын материалыг шилжүүлэх буюу хүлээн авахыг Хэлэлцэн тохирогч Талуудын Ерөнхий Прокурорын газруудаар дамжуулан хэрэгжүүлнэ.

44 дүгээр зүйл **Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцох этгээдийн эрх**

Хэлэлцэн тохирогч талууд эрүүгийн хэргийн мөрдөн байцаах ба шүүх ажиллагаанд оролцоход өөрийн улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид заасны дагуу иргэдийг эрхээ эдлэх боломжоор хангана.

ТАВДУГААР БҮЛЭГ **Бусад заалт**

45 дугаар зүйл **Баримт бичиг хүчин төгөлдөр байх**

1. Хэлэлцэн тохирогч нэг талын шүүх болон эрх бүхий бусад байгууллагаас үйлдсэн буюу гэрчилсэн баримт бичиг нь гарын үсэгтэй буюу албан ёсны тэмдэгтэй бол хүчин төгөлдөр байна. Энэхүү хэлбэрээр эдгээр баримт бичгийг нөгөө талын шүүх буюу эрх бүхий бусад байгууллага ямар нэгэн нотолгоогүйгээр хүлээж авна
2. Хэлэлцэн тохирогч нэг талын нутаг дэвсгэр дээр үйлдсэн албан ёсны баримт бичиг нь Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт нэг адил албан ёсны баримт бичиг нь нотлох чадвартай байна.

46 дугаар зүйл **Иргэний гэр бүлийн байдлын талаарх болон бусад баримт бичиг илгээх**

Энэхүү гэрээг биелүүлэх үүднээс Хэлэлцэн тохирогч нэг талын эрх бүхий байгууллага дипломат шугамаар гаргасан хүсэлтийн дагуу үнэ төлбөргүйгээр өөрийн улсын төрийн хэлээр буюу Орос хэлрүү хөрвүүлсэн хэлэлцэн тохирогч нөгөө талын иргэний хувийн эрхийг хөндөх иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн талаарх гэрчилгээ боловсролын болон хөдөлмөрийн хугацааны талаарх гэрчилгээ буюу бусад баримт бичгийг хэлэлцэн тохирогч нөгөө тал илгээнэ.

47 дугаар зүйл

Эд зүйл гаргах ба оруулах болон мөнгө гуйвуулах

Энэхүү гэрээний заалт болон түүнийг биелүүлэх нь хэлэлцэн тохирогч 2 талын хилийн чанадад эд зүйл гаргах ба оруулах болон мөнгө гуйвуулах тухай өөрийн улсын хууль дүрмийг биелүүлэхэд саад учруулахгүй.

48 дугаар зүйл

Маргааныг шийдвэрлэх

Энэхүү гэрээг тайлбарлах буюу биелүүлэхтэй холбогдсон асуудлаар гарах маргааныг дипломат шугамаар шийдвэрлэнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Төгсгөлийн заалт

49 дүгээр зүйл

Гэрээ хүчин төгөлдөр болох

Энэхүү гэрээг соёрхон батлах бөгөөд батламж жуух бичгийг Киев хотноо солилцсон өдрөөс хойш 30 хоногийн дараа гэрээг хүчин төгөлдөр болно.

50 дугаар зүйл

Гэрээний үйлчлэх хугацаа

1. Энэхүү гэрээг хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн хугацаанд хүчинтэй байна.
2. Хэрэв хэлэлцэн тохирогч аль нэг тал уг гэрээний хугацаа дуусахаас 6 сарын өмнө гэрээг цуцлах тухайгаа хэлэлцэн тохирогч нөгөө талд нотоор мэдэгдэхгүй бол гэрээ нь дараах 5 жилийн хугацаанд хүчинтэй байна.

1995 оны 6-р сарын 27-нд Киев хотноо Монгол, Украин хэлээр тус бүр 2 хувь үйлдсэн бөгөөд 2 эх адил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫН ӨМНӨӨС:

.....

УКРАЙН УЛСЫН ӨМНӨӨС:

.....